



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай" 9/36 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/48 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/48 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх Хот тохижилт, нийтийн аж ахуй, барилгын засвар, шинэчлэлтийн ажлын жагсаалтын 59, 60, 61, 62, 63, 64 дэх ажлууд, 2 дугаар хавсралтаар батлагдсан Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх Хот тохижилт, нийтийн аж ахуй, барилгын засвар, шинэчлэлтийн ажлын жагсаалтын 13, 14, 15, 16, 17, 18, 19 дугаар ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Дээрх ажлуудыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажиллахыг Үнэлгээний хороо /М.Гансэлэм/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны сарын
өдрийн тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд	Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Л.Булган	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Н.Энхбат	Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Чоймболын гудамж 55-64 тоотод оргин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Д.Батзориг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн